

"Улаанбаатар БУК-ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
№..... тоот Тогтоолын нээгдүгээр хавсралт

**"УЛААНБААТАР БУК" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Журмаар "УЛААНБААТАР БУК"ХК -ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргын (цаашид "НБД" гэх)-ийн эрх, үүрэг түүний үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь тухайн компанийн засаглалын асуудлыг хариуцах үндсэн ажилтан байна./ Нарийн бичгийн дарга нь компанийн удирдлагаас хараат бус байх бөгөөд дараах үндсэн үүргийг хүлээнэ:/
 - 1.2.1. Компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;
 - 1.2.2. Компанийн засаглалын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
 - 1.2.3. ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид ХЭХ гэх), Төлөөлөн удирдах зөвлөлийн/цаашид ТУЗ гэх/ хурлуудыг зарлан хуралдуулах, зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авах
 - 1.2.4. Хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад хэлтэс, газрууд үр үр дүнтэй мэдээлэл солилцоход хувь нэмрээ оруулах
 - 1.2.5. Компанийн мэдээлэл, харилцаа холбоо, олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаанд хяналт тавих
 - 1.2.6. Хувьцаа эзэмшигчээс ирсэн гомдол, хүсэлтийг хүлээн авч, тухайн асуудлыг шийдвэрлэхэд компанид туслах, компани доторх маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх
- 1.3. Нарийн бичгийн дарга нь энэ журмаар хүлээсэн эрх үүргээ ТУЗ-тэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу гүйцэтгэнэ.

ХОЁР. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ

- 2.1. Нарийн бичгийн даргыг компанийн ТУЗ-ийн даргын санал болгосноор нийт гишүүдийн олонхын саналаар томилно. Нарийн бичгийн даргад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:
 - 2.1.1. Дээд боловсрол;
 - 2.1.2. Нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын туршлага болон мэргэжлийн ур чадвартай байх
 - 2.1.3. Компанийн тухай хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй;
 - 2.1.4. Нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.
 - 2.1.5. Компанитай нэгдмэл сонирхолгүй, компанийн томоохон хувьцаа эзэмшигчдээс хараат бус этгээд байх
 - 2.1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 3-аас доошгүй жилийн ажлын туршлагатай

2.2. ТУЗ-ийн гишүүд нарийн бичгийн даргад нэр дэвшигчтэй холбоотой дараах мэдээллийг хүлээн авна:

2.2.1. Боловсрол, өнгөрсөн жилд хашиж байсан ажлын туршлага;

2.2.2. Компанид хувьцаа эзэмшдэг эсэх (хэрвээ эзэмшдэг бол хувьцааны тоо хэмжээ);

2.2.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд эсэх

2.2.4. Нарийн бичгийн даргын албан тушаалыг хашихад ноцтой нөлөөлөх бусад

2.3. Нарийн бичгийн даргатай хийгдэх хөдөлмөрийн гэрээний нөхцөлүүдийг зөвлөлөөс баталгаажуулах ба зөвлөлийг төлөөлж тухайн гэрээнд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

2.4. Нарийн бичгийн даргыг тухайн компанид өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглоно.

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН БҮРЭН ЭРХ

3.1. Компанийн засаглалын бодлого, үйл ажиллагаа

3.1.1 Олон улсын хэмжээнд явагдаж буй компанийн засаглалын шинэтгэлийг судлах, зөвлөл болон удирдлагын багт шинэтгэлийн талаар мэдээлэл хүргүүлэх, зөвлөх, эдгээр шинэтгэлүүдийг компани дээр хэрэгжүүлэх арга боломжийг судлах;

3.1.2 Компанийн засаглалын бодлого болон үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах санал, засаглалыг сайжруулах төлөвлөгөө, журмын төсөл боловсруулж зөвлөлд хүргүүлэх;

3.1.3 Компанийн дотоод бодлого, журмыг боловсруулахад компанийн гүйцэтгэх удирдлага болон бусад холбогдох албан тушаалтанд зөвлөх;

3.1.4 Шинээр сонгогдсон зөвлөлийн гишүүн болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтан, дотоод хяналтын ажилтанд компанийн засаглалын бодлого, журмыг танилцуулах;

3.2. Харилцаа холбоо, ил тод байдал:

3.2.1. Компанийн хуульчтай хамтарч ажиллах, мэдээлэл солилцох;

3.2.2. Компанийн талаарх мэдээлэл, тайлангуудыг холбогдох дүрэм журмын дагуу төрийн эрх бүхий байгууллагад хүргэж байгаа эсэхэд хяналт тавих;

3.2.3. Олон нийтэд ил болгох компанийн мэдээллийг хуульд заасан арга хэрэгслээр хүргэх асуудлыг хариуцах;

3.2.4. Хувьцаа эзэмшигч, зээл олгогчийн хүсэлтээр шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хүргэх асуудлыг хариуцах;

3.2.5. Компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, түүний дэргэдэх хороод, гүйцэтгэх удирдлага, бусад салбар, хэлтэс хоорондын мэдээлэл солилцооны үр дүнтэй байдлыг хангахад хувь нэмэр оруулж ажиллах;

3.2.6. Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, эрх бүхий этгээдийг тухайн мэдээлэлд зохих ёсоор нэвтрүүлэхэд хяналт тавих;

3.2.7. Нарийн бичгийн дарга нь өөрийн үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор компанийн бүх алба хэсэг ажилтнаас мэдээлэл авах эрхтэй.

3.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг зохион байгуулах:

3.3.1. ХЭХ болон ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулж явуулахдаа компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба дараах үүргийг хүлээнэ:

3.3.1.1. ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг компанийн бүртгэлийг үндэслэн гаргаж зөвлөлийн даргад хүргүүлэх;

3.3.1.2. ТУЗ-ийн хурлын товийг ТУЗ-ийн даргатай хэлэлцэн гаргаж, ТУЗ-ийн гишүүдэд мэдэгдэх;

3.3.1.3. ТУЗ-ийн баталгаажуулсан жагсаалтын дагуу хуралд оролцох хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, бусад эрх бүхий этгээдэд хурлын зарыг хүргүүлэх;

3.3.1.4. ХЭХ-ын зарын хамт хурлаар хэлэлцэх асуудлууд түүнд холбогдох мэдээлэл, баримт бичгүүд, хурлаас гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэргийг бэлтгэх, хуралд оролцогчид хурлын өмнө танилцах боломж, нөхцөлийг хангах;

3.3.1.5. Хувьцаа эзэмшигчдийн бөглөсөн саналын хуудсыг хураан авч тооллогын комисст шилжүүлэх ба зөвлөлийн гишүүдийн бөглөсөн саналын хуудсыг хураан авч зөвлөлийн даргад шилжүүлэх;

3.3.1.6. ХЭХ-ын тэмдэглэл хөтлөх ба баталгаажуулсан тэмдэглэл, шийдвэрийн хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

3.3.1.7. Хувьцаа эзэмшигчдэд (ТУЗ-ийн гишүүдэд) хурлын тэмдэглэл, шийдвэрийг танилцуулах, тэдгээрийн хүсэлтийн дагуу тэмдэглэлийн хувийг хүргүүлэх;

3.3.1.8. ХЭХ процесс, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөгөө өгөх, оролцогчдын асуултад хариулах;

3.3.1.9. ХЭХ-ыг хуралдуулах, удирдан явуулах явцад үүссэн маргаан, үл ойлголцлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авах.

3.4. Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт:

3.4.1. Компанийн хууль тогтоомжийг тухайн компани хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;

3.4.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон бусад ажилтнаас компанийн засаглалын бодлого, дүрэм журмыг зөрчсөн тохиолдлыг ТУЗ-ийн даргад нэн даруй мэдэгдэх. Хэрэв ТУЗ-ийн дарга, гишүүд компанийн дүрэм журмыг зөрчвөл ХЭХ-ийн хурал дээр зөрчлийг мэдэгдэх;

3.4.3. ТУЗ-д компанийн засаглалын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, анализ хийх болон сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлэх;

3.4.4. Компанийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн хооронд болон хувьцаа эзэмшигчид хооронд үүссэн сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд туслах, зуучлагчаар оролцох;

3.4.5. Компанийн бичиг баримтыг хадгалах, эрх бүхий албан тушаалтны шаардлагаар танилцуулах, хадгалах хугацаа нь дууссан баримт бичгийг архивт шилжүүлэх ажлыг хариуцахаас гадна хуулбарыг зохих этгээдэд хүсэлтийн дагуу гаргаж өгөх;

3.4.6. Компанийн хувьцаа эзэмшигчдээс ирсэн гомдол, саналыг хүлээн авч, бүртгэл хөтлөх, холбогдох газар, хэлтэс, ажилтанд хүлээлгэн өгч, хүлээн авсан этгээд уг гомдол, саналыг цаг хугацаанд нь барагдуулж, хариу өгч байгаа эсэхэд хяналт тавих;

БУСАД ЗААЛТ

4.1 Энэхүү журам нь ТУЗ-ийн баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна.